



МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2013 оны 11 сарын 06 өдөр

Дугаар 452

Улаанбаатар хот


Г “Үнэт цаасны зах зээлд оролцогчид аудитын үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдийг бүртгэх тухай”  
журам батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 24.1.17 дахь заалтыг үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Үнэт цаасны зах зээлд оролцогчид аудитын үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдийг бүртгэх тухай журам”-ыг хавсралтаар баталсугай.
2. Хороонд бүртгэлтэй үнэт цаас гаргагчид үйлчилгээ үзүүлэх аудитын байгууллагуудад 2014 оны 1 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн шинэчилсэн найруулга болон энэ тогтоолоор батлагдсан журамд нийцүүлэн бүртгэлээ шинэчлүүлэх арга хэмжээ авч ажиллахыг үүрэг болгосугай.
3. Батлагдсан журмын хэрэгжилт болон тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН



МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ

Санхүүгийн зохицуулах хорооны  
2013 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн  
162 бугаар тогтоолын хавсралт

УХА0410 5043239

## ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛД ОРОЛЦОГЧИД АУДИТЫН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙГ БҮРТГЭХ ТУХАЙ ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 24.1.17, 24.3 дахь заалтад тусгагдсан үнэт цаасны зах зээлд оролцогчид аудитын үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдийг бүртгэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2. Энэхүү журамд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно.

1.2.1. үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 4.1.16-д зааснаар “үнэт цаасны зах зээлд оролцогч” гэж үнэт цаас гаргагч, зохицуулалттай хуулийн этгээд болон хөрөнгө оруулагчийг;

1.2.2. үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 4.1.17-д “зохицуулалттай этгээд” гэж Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 24.2-д заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг Хорооноос авсан хуулийн этгээдийг;

1.2.3. үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 4.1.20-д зааснаар “үнэт цаас гаргагч” гэж үнэт цаасны зах зээлд арилжих үнэт цаасаа Хороонд бүртгүүлсэн, эсхүл бүртгүүлэх хүсэлт гаргаж байгаа хуулийн этгээдийг;

1.2.4. “аудитын байгууллага” гэж энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээдийг;

1.2.5. “бүртгэгдсэн этгээд” гэж Хорооны тавьсан шаардлагыг хангаж үнэт цаасны зах зээлд оролцогчид аудитын үйлчилгээ үзүүлэхээр Хороонд бүртгэгдсэн хуулийн этгээдийг;

1.3. Бүртгэгдсэн этгээд нь энэхүү журамд тавигдсан шаардлагыг биелүүлж ажиллах, аудиторуудын талаарх өөрчлөлтийг тухай бүр Хороонд ирүүлэх үүрэгтэй.

### Хоёр. Аудитын байгууллагад тавигдах шаардлага

2.1. Аудитын байгууллага дараах шаардлагыг хангасан байна:

2.1.1. аудитын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй, аудитын үйл ажиллагааг 1-ээс доошгүй жил эрхэлсэн байх;

2.1.2. Хороо, Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институт /цаашид “ММНБИ” гэх/-ээс зохион байгуулсан үнэт цаасны зах зээлийн талаарх төрөлжсөн сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан 2 ба түүнээс дээш орон тооны аудитортой байх;

2.1.3. аудиторууд нь тухайн аудитын байгууллагад б 6 сараас доошгүй хугацаанд ажиллаж нийгмийн даатгалын шимтгэл төлсөн байх;

2.1.4. аудиторууд нь мэргэжлийн ёс зүйн алдаа дутагдал гаргаж байгаагүй талаар ММНБИ-ээс тодорхойлолт гаргуулсан байх;

2.1.5. Хороо болон холбогдох эрх бүхий байгууллагаас зохион байгуулсан чанарын хяналтын шалгалтад хангалттай үнэлгээ авсан байх;

2.1.6. хууль тогтоомжид заасан бусад.

#### **Гурав. Аудитын байгууллагын бүрдүүлэх баримт бичиг**

3.1 Энэхүү журмын 2.1-д заасан шаардлагыг хангасан аудитын байгууллага нь Хороонд бүртгүүлэх хүсэлтээ дор дурдсан баримт бичгийн хамт ирүүлнэ:

3.1.1 бүртгүүлэхийг хүссэн өргөдөл /журмын 1-р хавсралт маягт/;

3.1.2. байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээний болон дүрмийн нотариатаар гэрчлүүлсэн хуулбар, холбогдох тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хуулбар;

3.1.3. орон тооны аудиторуудын аудитын үйл ажиллагааг эрхлэх зөвшөөрлийн гэрчилгээ, нийгмийн даатгалын дэвтрийн нотариатаар гэрчлүүлсэн хуулбар, мэргэжлийн байгууллагаас зохион байгуулсан төрөлжсөн сургалтад хамрагдсаныг гэрчлэх болон мэргэжлийн хариуцлагын даатгалд хамрагдсаныг нотлох баримт бичгийн хуулбар;

3.1.4. аудиторууд нь мэргэжлийн болон ёс зүйн зөрчил гаргаж байгаагүй тухай тодорхойлолт;

3.1.5. аудитын байгууллага нь үнэт цаасны зах зээлд оролцогчид аудитын үйлчилгээ үзүүлэх аудитын үйл ажиллагааны журам;

3.1.6. аудитын байгууллагын үйл ажиллагааны талаарх түүхчилсэн дэлгэрэнгүй танилцуулга.

#### **Дөрөв. Аудитын байгууллагыг бүртгэх, бүртгэлээс хасах**

4.1. Хороо аудитын байгууллагаас ирүүлсэн баримт бичгийг хүлээн авсанаас хойш ажлын 20 хоногийн дотор хянаж шийдвэрлэнэ.

4.2. Хороо аудитын байгууллагыг шаардлага хангасан гэж үзвэл үнэт цаасны зах зээлд оролцогчид үйлчилгээ үзүүлэх этгээдээр бүртгэнэ.

4.3. Хороо бүртгэхээс татгалзсан тохиолдолд энэ тухай үндэслэл бүхий мэдэгдлийг хүсэлт гаргасан этгээдэд албан бичгээр мэдэгдэнэ.

4.4. Хороонд бүртгэгдсэн аудитын байгууллагыг дор дурдсан шалтгаанаар бүртгэлээс хасна:

4.4.1. аудитын байгууллага өөрөө хүсэлт гаргасан;

4.4.2. энэхүү журмын 2, 3.1.1-3.1.4-т заасан шаардлагуудын аль нэгийг болон бүгдийг хангахгүй болсон;

4.4.3. бүртгүүлэхдээ хуурамч баримт бичиг бүрдүүлсэн нь тогтоогдсон;

4.4.4. бодит бус тохиромжгүй дүгнэлт гаргасан, дагаж мөрдвөл зохих хууль, дүрэм, журам, стандартыг зөрчсөн, мэргэжлийн ноцтой алдаа гаргасан, үйлчлүүлэгчийн болон нийтийн ашиг сонирхолд хохирол учруулсан, түүнтэй адилтгах нөхцөл байдал үүссэн;

4.4.5 Хороо ашиг сонирхолын зөрчил бүхий нөхцөл байдал бий болсон гэж үзсэн;

4.4.6. холбогдох хууль тогтоомж зөрчсөн нь тогтоогдсон.

4.5. Энэхүү журмын 4.4.2-д зааснаас бусад үндэслэлээр бүртгэлээс хасагдсан этгээд бүртгэлээс хасагдсанаас хойш 3 жилийн хугацаанд Хороонд дахин бүртгүүлэхээр хандах эрхгүй.

4.6. бүртгүүлэхээр хүсэлт гаргасан болон бүртгэлтэй хуулийн этгээд энэхүү журмын 4.5-д заасан үндэслэлээр бүртгэлээс хасагдсан аудитын байгууллагад ажиллаж байсан зохих мэргэжлийн болон хууль хяналтын байгууллагас буруутай нь тогтоогдсон аудиторыг 3 жилийн хугацаагаар авч ажиллуулахыг хориглоно.

4.7. Хорооны тусгай зөвшөөрөл, эрхийн нэгдсэн бүртгэл хариуцсан ажилтан үнэт цаасны зах зээлд оролцогчид аудитын үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдийг бүртгэсэн, бүртгэлээс хассан талаарх дэлгэрэнгүй бүртгэлийг хөтөлнө.

4.8. үнэт цаасны зах зээлд оролцогчид аудитын үйлчилгээ үзүүлэх этгээдийг бүртгэсэн, бүртгэлээс хассан тухай шийдвэрийг Хороо ажлын 10 хоногт багтаан үнэт цаас гаргагч, олон нийтэд цахим сүлжээгээр мэдээлнэ.

**Тав. Үнэт цаасны зах зээлд оролцогчид үйлчилгээ үзүүлэх  
аудиторуудын төрөлжсөн сургалт**

5.1. Үнэт цаасны зах зээлийн чиглэлээр төрөлжсөн сургалтыг Хороо, ММНБИ -тэй хамтран зохион байгуулна.

5.2. Үнэт цаасны зах зээлд оролцогчид үйлчилгээ үзүүлэх аудиторууд нь үнэт цаасны зах зээлийн чиглэлээр төрөлжсөн сургалтад 3 жил тутам хамрагдаж, зохих шалгалт ёгч гэрчилгээ авсан байна.

**Зургаа. Аудитын дүгнэлт, түүний хяналт**

6.1. Үнэт цаасны зах зээлд оролцогчид аудитын үйлчилгээ үзүүлэхээр бүртгэгдсэн этгээд нь үнэт цаасны зах зээлд оролцогчид үйлчилгээ үзүүлэхдээ холбогдох хууль тогтоомж, аудитын олон улсын стандарт, эрх бүхий байгууллагаас батлан гаргасан журам заавар арга, аргачлалыг мөрдөнө.

6.2. Аудитын байгууллагаас үнэт цаасны зах зээлд оролцогчид санхүүгийн болон бусад үйл ажиллагааны талаар гаргасан тайлан дүгнэлтийг Хорооны Эрсдэлийн үнэлгээ, судалгаа, санхүүгийн шинэ бүтээгдэхүүн үйлчилгээний газар хянаж хүлээн зөвшөөрөх эсэх талаар үндэслэл бүхий санал, дүгнэлтээ Үнэт цаасны газарт хүргүүлнэ.

6.3. Хороо аудитын чанарын хяналт хийж, бүртгэлийн нөхцөл шаардлагын биелэлтэд хяналт тавьж, шалгалт хийнэ.

#### **Долоо. Хариуцлага**

7.1. Хороо энэхүү журам болон холбогдох хууль тогтоомжийг зөрчсөн этгээдийг холбогдох мэргэжлийн байгууллагуудад нь мэдэгдэх, үнэт цаасны зах зээлд оролцогчид аудитын үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдийн бүртгэлээс хасах, хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр дамжуулан олон нийтэд мэдэгдэнэ.

7.2. бүртгэлтэй хуулийн этгээдийн аливаа хууль зөрчсөн үйл ажиллагаа нь гэмт хэргийн шинжтэй гэж үзвэл Хороо хууль хяналтын байгууллагад хандаж шалгуулна.

---ooOoo---

“Үнэт цаасны зах зээлд оролцогчид аудитын үйлчилгээ  
үзүүлэх хуулийн этгээдийг бүртгэх тухай эсуралт”-ын 1  
дүгээр хавсралт

## БҮРТГҮҮЛЭХИЙГ ХҮССЭН ӨРГӨДӨЛ

Огноо: .....

Хаана: Санхүүгийн зохицуулах хороо,  
Засгийн газрын IV байр  
Бага тойруу -3  
Улаанбаатар -15160  
Монгол улс.

Хэнээс: .....

(өргөдөл гаргагчийн овог, нэр, эрхэлж буй албан тушаал, байгууллагын хаяг, утас, факс, электрон шуудангийн хаяг)

/Аудитын байгууллагын нэр ХК, ХХК, ЗБН/

Хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүн:

№	Овог, нэр /Хуулийн этгээдийн нэр/	Регистрийн дугаар	Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар	Хаяг	Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувь (мянган .төгрөгөөр)

Байгууллагын гүйцэтгэх удирдлагын эрх бүхий албан тушаалтан нь /гүйцэтгэх  
захирал, нэгжийн удирдлага, дотоод хяналтын ажилтнууд/ дараах хумүүс болно:

№	Овог, нэр	Одоогийн эрхэлж байгаа ажил	Регистрийн дугаар	Мэргэжлийн байгууллагад эрхлэх албан тушаал

Аудитын үйлчилгээ үзүүлэх аудиторууд нь дараах хумүүс болно:

№	Овог, нэр	Регистрийн дугаар	Гэрийн хаяг	Тухайн ажил үйлчилгээг эрхэлсэн хугацаа	Албан тушаал	Тухайн ажил үйлчилгээг эрхлэх эрхийн үнэмлэхийн дугаар


Бүртгүүлэхээр хүргүүлсэн баримтыг Санхүүгийн зохицуулах хорооны 201 оны ... дугаар сарын ...-ний өдрийн .. дүгээр тогтоолоор батлагдсан "Үнэт цаасны зах зээлд оролцогчид аудитын үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдийг бүртгэх тухай журам"-ын шаардлагад нийцүүлэн үнэн зөв бүрдүүлсэн болно. Бүрдүүлсэн бичиг баримтад аливаа худал ташаа зүйл байвал хариуцлагыг бид хүлээх болно.

Өргөдөл, холбогдох бичиг баримтыг хянан шалгажс, үнэт цаасны зах зээлд оролцогчийн үйл ажиллагаатай холбоотой дүгнэлт гаргах этгээдээр бүртгэн авна уу.

Бид үйл ажиллагаандaa Иргэний хууль, Компанийн тухай, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Аудитын тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжс, журам заавруудыг мөрдлөг болгон ажиллах ба Санхүүгийн зохицуулах хорооноос тавьсан шаардлагуудыг бүрэн биелүүлжс байх болно.

#### ӨРГӨДӨЛ ГАРГАГЧ:

/......./ /......./  
/гарын үсэг/ /овог, нэр /

/......./ / албан тушаал /

/ тамга тэмдэг/

“Үнэт цаасны зах зээлд оролцогчид аудитын үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдийг бүртгэх тухай эсуралт”-ын 1 дүгээр хавсралт

## БҮРТГҮҮЛЭХИЙГ ХҮССЭН ӨРГӨДӨЛ

Огноо : .....

Хаана: Санхүүгийн зохицуулах хороо,  
Засгийн газрын IV байр  
Бага тойруу -3  
Улаанбаатар -15160  
Монгол улс.

Хэнээс: .....

(өргөдөл гаргагчийн овог, нэр, эрхэлж буй албан тушаал, байгууллагын хаяг, утас, факс, электрон шуудангийн хаяг)

/Аудитын байгууллагын нэр ХК, ХХК, ЗБН/

Хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүн:

№	Овог, нэр /Хуулийн этгээдийн нэр/	Регистрийн дугаар	Хуулийн этгээдийн услын бүртгэлийн гэрчилгээний дугаар	Хаяг	Хувь нийлуулсэн хөрөнгийн хэмжээ, хувь (мянган .төгрөгөөр)

Байгууллагын гүйцэтгэх удирдлагын эрх бүхий албан тушаалтан нь /гүйцэтгэх захирал, нэгжийн удирдлага, дотоод хяналтын ажилтнууд/ дараах хүмүүс болно:

№	Овог, нэр	Одоогийн эрхэлж байгаа ажил	Регистрийн дугаар	Мэргэжлийн байгууллагад эрхлэх албан тушаал

Аудитын үйлчилгээ үзүүлэх аудиторууд нь дараах хүмүүс болно:

№	Овог, нэр	Регистрийн дугаар	Гэрийн хаяг	Тухайн ажил үйлчилгээг эрхэлсэн хугацаа	Албан тушаал	Тухайн ажил үйлчилгээг эрхлэх эрхийн үнэмлэхийн дугаар